| 16 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | - | - | - | - |
| **17** | **2025 оны 06-р сарын 30-ны өдрийн үлдэгдэл** | **188,774,062,500** | **14,652,725,000** | **-** | **42,310,184,890** | **27,078,638,903** | **343,168,726,722** | **615,984,338,015** |

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ө.ГАНТӨР

ЭРСДЭЛ, САНХҮҮ ХАРИУЦСАН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ОРЛОГЧ Х.ЛХАГВАСҮРЭН

САНХҮҮГИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ Д.ЖАДАМБАА

САНХҮҮГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТЫН МЭРГЭЖИЛТЭН Э.ТҮВШИНЖАРГАЛ

ТАЙЛАН МЭДЭЭНИЙ ХЭЛТСИЙН ЗАХИРАЛ Д.ЛХАГВАСҮРЭН

ТАЙЛАН МЭДЭЭНИЙ ХЭЛТСИЙН ХЯНАЛТЫН МЭРГЭЖИЛТЭН Д.НАРАНЦАЦРАЛ

ТАЙЛАН МЭДЭЭНИЙ ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Д.ЖАРГАЛМАА

# ТӨРИЙН БАНКНЫ ТЭНЦЛИЙН ГАДУУРХ ДАНСНЫ ҮЛДЭГДЛИЙН ТАЙЛАН

2025 оны 06 дугаар сарын 30

Төгрөгөөр

| Дансны код | Дансны нэр | Дүн |
|---|---|---:|
| | **Тэнцлийн гадуурх дансуул** | 13,924,259,804,852.1 |
| **61000000** | **Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах үүрэг** | 26,710,621,693.2 |
| 61010000 | Банкны гаргасан баталгаа | - |
| 61020000 | Импортын баталгаа | - |
| 61030000 | Экспортын баталгаа | - |
| 61040000 | Урьдчилгаа төлбөрийн баталгаа | 82,377,025.0 |
| 61050000 | Банкны гаргасан батлан даалт | - |
| 61060000 | Векселийн батлан даалт | - |
| 61070000 | Харилцагчийн өмнөөс гаргасан аккредитивын батлан даалт | |
| 61080000 | Тендерийн батлан даалт | 2,125,797,589.0 |
| 61090000 | Гүйцэтгэлийн батлан даалт | 11,574,411,852.6 |
| 61100000 | Импортын аккредитив | 334,601,415.3 |
| 61110000 | Экспортын аккредитив | - |
| 61120000 | Зээлийн шугам | 4,104,528,293.6 |
| 61130000 | Овердрафтын зээлийн шугам | 8,488,905,517.7 |
| 61140000 | Худалдсан зээлтэй холбоотой хүлээж болзошгүй үүрэг | - |
| 61150000 | Үйл ажиллагааны түрээсээр хүлээсэн үүрэг | - |
| 61160000 | Хамтын зээлжүүлэлтээр хүлээсэн үүрэг | - |
| 61170000 | Бусад болзошгүй үүрэг | - |
| **62000000** | **Барьцаа хөрөнгө** | 11,899,280,548,064.9 |
| 62010000 | Үнэт цаас | - |
| 62020000 | Хөдлөх хөрөнгө | 255,357,981,403.3 |
| 62030000 | Үл хөдлөх хөрөнгө | 3,919,603,352,877.7 |
| 62040000 | Үнэт металл | - |
| 62050000 | Бусдаас авсан баталгаа, батлан даалт | 259,664,595,444.0 |
| 62060000 | Бусад барьцаа | 7,464,654,618,339.8 |
| **63000000** | **Тэнцлээс хассан хөрөнгө** | 99,135,842,189.9 |
| 63100000 | Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө | - |
| 63200000 | Үнэт цаасны эрсдэлийн сангаар хаасан үнэт цаас | - |
| 63300000 | Зээлийн эрсдэлийн сангаар хаасан зээл | 1,235,794,974.9 |
| 63400000 | Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сангаар хаасан хөрөнгө | - |
| 63500000 | Үнэт металлын эрсдэлийн сангаар хаасан үнэт металл | - |
| 63600000 | Авлагын эрсдэлийн сангаар хаасан авлага | 453,482,858.6 |
| 63700000 | Хуримтлуулж тооцохыг зогсоосон хүү | 97,446,564,356.5 |
| **64000000** | **Дериватив санхүүгийн хэрэгсэл** | 1,024,692,863,184.7 |
| 64100000 | *Спот арилжаа* | - |
| 64101000 | Гадаад валютын арилжааны авлага | - |
| 64102000 | Гадаад валютын арилжааны өглөг | - |
| 64103000 | Үнэт металлын арилжааны авлага | - |
| 64104000 | Үнэт металлын арилжааны өглөг | - |
| 64105000 | Үнэт цаасны арилжааны авлага | - |
| 64106000 | Үнэт цаасны арилжааны өглөг | - |
| 64200000 | *Форвард* | - |
| 64201000 | Гадаад валютын арилжааны авлага | |
| 64202000 | Гадаад валютын арилжааны өглөг | |
| 64203000 | Үнэт металлын арилжааны авлага | |
| 64204000 | Үнэт металлын арилжааны өглөг | |
| 64205000 | Үнэт цаасны арилжааны авлага | |
| 64206000 | Үнэт цаасны арилжааны өглөг | |
| 64300000 | *Своп* | 1,021,311,620,000.0 |
| 64301000 | Гадаад валютын арилжааны авлага | 519,202,950,000.0 |
| 64302000 | Гадаад валютын арилжааны өглөг | 502,108,670,000.0 |
| 64303000 | Үнэт металлын арилжааны авлага | - |
| 64304000 | Үнэт металлын арилжааны өглөг | - |
| 64305000 | Үнэт цаасны арилжааны авлага | - |
| 64306000 | Үнэт цаасны арилжааны өглөг | - |
| 64307000 | Тогтмол хүүгийн түвшний своп | - |
| 64308000 | Хөвөгч хүүгийн түвшний своп | - |
| 64309000 | Индекс | - |
| 64310000 | Бусад | - |
| 64400000 | *Опцион* | 3,381,243,184.7 |
| 64401000 | Гадаад валютын арилжааны авлага | 1,746,718,141.6 |
| 64402000 | Гадаад валютын арилжааны өглөг | 1,634,525,043.1 |
| 64403000 | Үнэт металлын арилжааны авлага | - |
| 64404000 | Үнэт металлын арилжааны өглөг | - |
| 64405000 | Үнэт цаасны арилжааны авлага | - |
| 64406000 | Үнэт цаасны арилжааны өглөг | - |
| 64407000 | Бараа, бүтээгдэхүүний арилжааны авлага | - |
| 64408000 | Бараа, бүтээгдэхүүний арилжааны өглөг | - |
| 64500000 | *Фьючерс* | - |
| 64501000 | Гадаад валютын арилжааны авлага | |

| | | | |
|---|---|---|---|
| | 64502000 | Гадаад валютын арилжааны өглөг | |
| | 64503000 | Үнэт металлын арилжааны авлага | |
| | 64504000 | Үнэт металлын арилжааны өглөг | |
| | 64505000 | Үнэт цаасны арилжааны авлага | |
| | 64506000 | Үнэт цаасны арилжааны өглөг | |
| | 64507000 | Бараа, бүтээгдэхүүний арилжааны авлага | |
| | 64508000 | Бараа, бүтээгдэхүүний арилжааны өглөг | |
| | 64600000 | *Бусад дериватив* | - |
| | 64601000 | Гадаад валютын арилжааны авлага | |
| | 64602000 | Гадаад валютын арилжааны өглөг | |
| | 64603000 | Үнэт металлын арилжааны авлага | |
| | 64604000 | Үнэт металлын арилжааны өглөг | |
| | 64605000 | Үнэт цаасны арилжааны авлага | |
| | 64606000 | Үнэт цаасны арилжааны өглөг | |
| | 64607000 | Бараа, бүтээгдэхүүний арилжааны авлага | |
| | 64608000 | Бараа, бүтээгдэхүүний арилжааны өглөг | |
| | 64700000 | *Хэрэгжээгүй орлого, зардлын цэвэр дүн* | |
| **65000000** | | **Харилцагчийн өмнөөс батлан даасан хөрөнгө** | - |
| | 65100000 | *Үнэт цаасны хадгаламж (кастодиан)* | - |
| | 65110000 | Компанийн хувьцаа, нэрлэсэн үнээрээ | |
| | 65120000 | Компанийн бонд, нэрлэсэн үнээрээ | |
| | 65130000 | Компанийн вексел, нэрлэсэн үнээрээ | |
| | 65140000 | Эргүүлэн худалдах буюу худалдан авах нөхцлөөр авсан үнэт цаас | |
| | 65150000 | Засгийн газрын бонд, нэрлэсэн үнээрээ | |
| | 65160000 | Орон нутгийн бонд, нэрлэсэн үнээрээ | |
| | 65170000 | Засгийн газрын үнэт цаас, нэрлэсэн үнээрээ | |
| | 65180000 | Бусад зүйлс, нэрлэсэн үнээрээ | |
| | 65200000 | *Бусад хөрөнгө* | |
| **66000000** | | **Барьцаанд тавьсан хөрөнгө** | **188,792,934,783.0** |
| | 66010000 | Мөнгөн хөрөнгө ба бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж | - |
| | 66020000 | Үнэт цаас | 188,792,934,783.0 |
| | 66030000 | Авлага | - |
| | 66040000 | Зээл | - |
| | 66050000 | Хөрөнгө оруулалтын зорнулалттай үл хөдлөх хөрөнгө | - |
| | 66060000 | Барилга, байгууламж | - |
| | 66070000 | Үнэт металл | - |
| | 66080000 | Бусад хөрөнгө | - |
| **67000000** | | **Тэнцлийн гадуурх бусад дансууд** | **685,646,994,936.3** |
| | 67010000 | Гадаад худалдааны санхүүжилтанд зориулан гадаадын банкуудад нээсэн шугам | - |
| | 67020000 | Гадаадын банкуудад нээсэн бусад шугам | - |
| | 67030000 | Худалдааны санхүүжилтээр дотоодын банкуудад нээсэн шугам | - |
| | 67040000 | Дотоодын банкуудад нээсэн бусад шугам | - |
| | 67050000 | Бусад компани, банкны өмнөөс удирдах хөрөнгө | - |
| | 67060000 | Хамтын зээлжүүлэлтийн оролцогч банкинд хамаарах зээл | - |
| | 67070000 | Эрсдэлийг шилжүүлж худалдсан зээл | 599,640,353,131.7 |
| | 67080000 | Үүрэг хүлээлгүй баталсан баталгааны шугам | - |
| | 67090000 | Үүрэг хүлээлгүй баталсан зээлийн шугам | - |
| | 67100000 | Хүлээж авсан дотоодын инкасс | - |
| | 67110000 | Хугацаандаа төлөгдөөгүй дотоодын инкасс | - |
| | 67120000 | Хүлээж авсан гадаадын инкасс | - |
| | 67130000 | Хугацаандаа төлөгдөөгүй гадаадын инкасс | - |
| | 67140000 | Гадагш явуулсан нэхэмжлэл | - |
| | 67150000 | Гаднаас ирүүлсэн нэхэмжлэл | - |
| | 67160000 | Хадгалсан үнэ бүхий зүйл | 13,074.0 |
| | 67170000 | Борлуулахаар авсан гадаадын чек | - |
| | 67180000 | Борлуулсан үнэт цаас, чек | - |
| | 67190000 | Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, чекийн загвар | 65,849.0 |
| | 67200000 | Банкны ажилд хэрэглэж буй тэмдэгүүд | 9,933.0 |
| | 67210000 | Цахим карт | 12,060.0 |
| | 67220000 | Бусад | 86,006,540,888.6 |

Тайланг үнэн зөв гаргасан:

| | |
|---|---|
| Гүйцэтгэх захирал | Ө.Гантөр |
| Эрсдэл, санхүү хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч | Х.Лхагвасүрэн |
| Санхүүгийн газрын захирал | Д.Жадамбаа |
| Санхүүгийн газрын хяналтын мэргэжилтэн | Э.Түвшинжаргал |
| Тайлан мэдээний хэлтсийн захирал | Д.Лхагвасүрэн |
| Тайлан мэдээний хэлтсийн хяналтын мэргэжилтэн | Д.Наранцацрал |
| Тайлан мэдээний хэлтсийн тайлангийн мэргэжилтэн | Г.Ганбаяр |

УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК 5341469 ГСТ5382

Хавсралт 3

# СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
/2025.01.01-2025.06.30/

2025.06.30

Тайлант хугацаанд "Төрийн банк ХК-ийн сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6.1 дэх заалтад "Банкны "Үйлчилгээний хүү шимттэлийн ерөнхий нөхцөл"-д заасан нийтлэг нөхцөлөөр банкны холбогдох бодлого, журамд заасан шаардлагыг хангуулан, олон нийтэд санал болгож буй ердийн журмаар бизнесийн болон төслийн зээлээс бусад жижиг зээл, харилцах, хадгаламж болон карт, цахим банкны үйлчилгээтэй холбогдох хэлцэл байгуулах" гэж заасны дагуу Гүйцэтгэх захирлын эрх хэмжээний хүрээнд нийт 1,245 удаагийн сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдсэн. Үүнд:

1. Карт – 60
2. Зээл – 44
3. Хадгаламж барьцаалсан онлайн зээл – 953
4. Харилцах хадгаламж - 109
5. Автомат хуримтлал - 2
6. Батлан даалтын эх үүсвэр – 3
7. Интернэт банк – 6
8. Мессеж мэдээ - 7
9. Мобайл банк – 16
10. Өглөг / mnt – 25
11. Хувийн дугаар – 9
12. Хураамжийн авлага /mnt/ - 5
13. Гэрээ - 6

ХЯНАСАН:
КОМПЛАЙНСЫН ГАЗРЫН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.ЗОРИГТ

БОЛОВСРУУЛСАН:
КОМПЛАЙНСЫН ГАЗРЫН
МЭРГЭЖИЛТЭН Ч.ТҮВШИНБАЯР

# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын банк, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хадгаламж эзэмшигчид, харилцагчдын эрх ашгийг хамгаалах үүднээс Монгол Улсын Засгийн Газрын 2009 оны 348 дугаар тогтоол, Сангийн сайдын 2009 оны 259 дугаар тушаалын дагуу 100 хувь Төрийн өмчит “Төрийн банк”-ийг үүсгэн байгуулахаар шийдвэрлэж, Банкны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 375 дугаар тушаалаар батлагдсан “Банк түүний нэгж байгуулах зөвшөөрлийн журам”-ыг тус тус үндэслэн 2009 оны арваннэгдүгээр сарын 23-ны өдөр байгуулагдсанаас хойш өдгөө 16 дахь жилдээ үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн хурлаас Төрийн банкийг “Дундаж давхаргыг дэмжигч банк” болгохоор шийдвэрлэсний дагуу Банк нь Монгол орон даяар 497 салбар нэгжээр дамжуулан, 2,3 сая харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлсэн, байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, ил тод, сайн засаглалтай, дундаж давхаргыг дэмжихэд чиглэсэн санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэт технологи ашиглан хүртээмжтэй хүргэх тогтолцоог бүрдүүлэх зорилгыг эрхэмлэн, дундаж давхаргыг дэмжигч, үндэсний тэргүүлэгч банк болох алсын хараатай ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн нэгдсэн чуулганаар Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Төрийн банк” ХК нь системийн нөлөө бүхий банкнуудаа түүчээлж нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжсэнээр хувь нийлүүлэгчдийн эзэмшлийн хувьд 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Сангийн яам 49.26 хувь, Хадгаламж даатгалын корпораци 45.03 хувь, олон нийт 5.71 хувийг тус тус эзэмшиж байна.

**Төлөөлөн удирдах зөвлөл:**

“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын 05 дугаар тогтоолоор “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-ыг олон улсад хэрэгжиж буй засаглалын сайн практик, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-д тус тус нийцүүлэн шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Шинэчлэгдэн батлагдсан Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурал сар бүр тогтмол, шаардлагатай нөхцөлд тухай бүр хуралдаж, ногдол ашиг хуваарилах, гүйцэтгэх удирдлагын гэрээ сунгах, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлттэй танилцах, эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэх, холбогдох бодлого журмыг батлах, Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, шийдвэрийг хэрэгжилтийг хангуулах зэрэг

асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж үүрэг даалгавар, чиглэл өгч ажилласан байна.

Төлөөлөн удирдах зөвлөл 2025 оны эхний хагас жилд ээлжит болон ээлжит бусаар нийт 7 удаа хуралдан, 27 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, 62 тогтоол гаргаж, 4 үүрэг даалгавар өгч, Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх, үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын ирц тогтмол 80%-иас дээш хувьтай хуралдсан бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг тухай бүр Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга хөтөлж, тогтоолын биелэлтийг Гүйцэтгэх удирдлага болон Дотоод аудитын газраас гаргуулан хяналт тавин ажиллаж байна.

Түүнчлэн, Банкны тухай хууль, Компанийн тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр зарлан хуралдуулж “Төрийн банк” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудлыг хэлэлцэн, Хувьцаа эзэмшигчдэд “Төрийн банк” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, “Төрийн банк” ХК-ийн 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилсан тухай, “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд 2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай асуудлыг тус тус танилцуулсан.

**ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл:**

“Төрийн банк” ХК-ийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу ТУЗ нь хараат бус 4, ердийн 5 буюу нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар шинэчлэн тогтоосон бөгөөд ТУЗ-ийн хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг 2024 оны 4 дүгээр сарын 22-ны өдрөөс 5 дугаар сарын 13-ны өдрийн хооронд зохион байгуулж, ТУЗ-ийн хараат бус гишүүнд хууль тогтоомжийн дагуу тавигдсан шаардлага хангасан 5 нэр дэвшигч болон төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх ТУЗ-ийн 5 ердийн гишүүнд холбогдох материалыг Монголбанканд хүргүүлж, хувьцаа эзэмшигчдийн хуралд нэр дэвшүүлэхэд шаардлагатай холбогдох зөвшөөрлийг авсан.

Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт заасан шаардлагыг бүрэн хангах, Төлөөлөн удирдах зөвлөл нь нийт 9 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулах шаардлагын хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтад оролцож, Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан шаардлагыг бүрэн хангасан З.Оюунцацралыг, “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний үүрэгт ажлаас 2024 оны 9 дүгээр сарын 11-ний өдрөөс чөлөөлөгдөх хүсэлтээ Д.Энхжаргалын оронд Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтад оролцож, Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан шаардлагыг бүрэн хангасан Б.Цэвэгжавыг 2024 оны 9 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн, Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн Д.Цолмонгийн оронд Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтад оролцож, Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан шаардлагыг бүрэн хангасан Х.Пүрэвсүрэнг 2024 оны 9 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн тус тус нөхөн сонгууль хүртэлх хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр түр томилсон.

**ТУЗ-ийн дарга:**

- Б.Тэлмүүн - Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга. МУИС-ийн Олон улсын харилцааны сургуульд олон улсын эдийн засгийн харилцаа бакалавр, СЭЗДС-д Санхүүгийн удирдлагын бакалавр, МУИС–ийн Хууль зүйн сургуульд олон улсын эрх зүйн магистр, АНУ-ын Корнеллийн Их сургуульд эдийн засаг, санхүүгийн бодлогын чиглэлээр нийтийн удирдлагын магистрын зэргээр тус тус боловсрол эзэмшсэн. 2010-2022 онд Сангийн яаманд Төсвийн бодлого, төлөвлөлтийн газарт мэргэжилтэн, хэлтсийн дарга, газрын дарга, Татварын ерөнхий газрын дэргэдэх Татварын маргаан таслах зөвлөлийн гишүүн, даргаар тус тус ажилласан ажлын туршлагатай.

**Гишүүд:**

- Б.Ганбат - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга. ЗХУ-ын Дотоод явдлын яамны Академийн хууль эрх зүй бакалавр, ИБУИНВУ-ын Коммонвелт хуулийн коллежид Хууль эрх зүйн магистрын зэргээр тус тус боловсрол эзэмшсэн. 1995-2016 онд Сангийн яаманд хуулийн зөвлөх, мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, хэлтсийн дарга, Сайдын зөвлөлийн нарийн бичгийн дарга, газрын орлогч дарга, газрын дарга, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт газрын дарга, Тэргүүн дэд даргаар тус тус ажилласан ажлын туршлагатай. Монгол Улсын гавьяат хуульч.
- Г.Золбоо – Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга. МУИС–ийн Эдийн засгийн сургуулийн банкны эдийн засагч бакалавр, ИБУИНВУ-ын Уельсийн их сургуулийн олон улсын бизнесийн менежментийн чиглэлээр боловсрол эзэмшсэн. 2013-2022 оны хооронд Сангийн яаманд зөвлөх, хэлтсийн дарга, газрын даргаар тус тус ажилласан ажлын туршлагатай.
- Л.Сонор – Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга. АНУ-ын Такома коммюнити коллежийн Бизнесийн удирдлага, АНУ-ын Вашингтоны их сургуулийн Санхүү, бизнесийн удирдлагын бакалавр зэргээр боловсрол эзэмшсэн. 2015-2022 онд Сангийн яаманд Санхүүгийн бодлогын газарт зөвлөх, мэргэжилтэн, хэлтсийн даргаар тус тус ажилласан ажлын туршлагатай.
- Х.Пүрэвсүрэн - МУИС-ийн нягтлан бодогч, эдийн засагч магистр, Голланд Улсын Маастрихтийн менежментийн их сургуульд нягтлан бодох, эдийн засгийн менежментийн чиглэлээр тус тус боловсрол эзэмшсэн. 1992-1996 онд СЭЗИС-д багш, тэнхимийн эрхлэгч, 1996-1997 онд "Говь" ХК-д эдийн засгийн хэлтсийн дарга, 1997-1999 онд Төрийн өмчийн хороонд албаны дарга, 1999-2016 онд Сангийн яаманд газрын дарга, Сангийн сайдын зөвлөхөөр ажиллаж байсан ажлын туршлагатай.
- Хараат бус гишүүн М.Батжаргал - Хөдөө аж ахуйн дээд сургуулийг эдийн засагч бакалавр, эдийн засгийн ухааны магистрын зэргээр боловсрол эзэмшсэн. 1975-1989 онд Улсын банканд эдийн засагч, орлогч дарга, Увс аймгийн Арбитр - Ерөнхий арбитрч, 1993-2008 онд Монголбанканд газрын захирал, ерөнхий захирал, ахлах ажилтан, ахлах хянан шалгагч, Хяналт шалгалтын хэлтсийн захирал, Дотоод аудитын газрын ахлах хянан шалгагч, аудитын зөвлөхөөр тус тус ажилласан ажлын туршлагатай. Монгол Улсын гавьяат эдийн засагч.
- Хараат бус гишүүн С.Цэнд-Аюуш – Санхүүч, ОХУ-ын Эрхүү хотын Улс Ардын Аж Ахуйн дээд сургуульд санхүүч бакалаврын зэргээр боловсрол эзэмшсэн. 1978-2015 онд Сангийн яаманд Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар мэргэжилтэн, ахлах мэргэжилтнээр тус тус ажилласан ажлын туршлагатай. Монгол Улсын гавьяат эдийн засагч.

- Хараат бус гишүүн З.Оюунцацрал – Эдийн засгийн коллежийн банк, зээлийн эдийн засагч бакалавр, БНСУ-ын Хандонг глобал их сургуулийн бизнесийн удирдлагын магистр, зэргээр боловсрол эзэмшсэн. СЭЗИС-ийн удирдахуйн ухааны доктор зэрэгтэй. 1996 оноос өнөөг хүртэл СЭЗИС-д багш, тэнхимийн эрхлэгч, профессороор ажилласан туршлагатай.
- Хараат бус гишүүн Б.Цэвэгжав – СЭЗИС-ийн банкны удирдлагын бакалавр, МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн бизнесийн удирдлагын магистр зэргээр тус тус боловсрол эзэмшсэн. 2002-2014 онд Капитрон банканд нягтлан бодогч, эдийн засагч, дилер, салбарын захирал, 2014-2015 онд Богд банк байгуулах төсөл, хөрөнгийн удирдлага хариуцсан гишүүн, 2015-2017 онд “Мегамакс групп” ХХК-д санхүү хариуцсан захирал, 2017-2023 онд “Эрдэнэс Монгол” ХХК-д албаны дарга, хэлтсийн дарга, 2022-2023 онд “Багануур” ХК-ийн ТУЗ-ийн дарга, “Эрдэнэс силвер ресурс” ХХК, “Гашуун сухайт авто зам” ХХК, “Метан газ ресурс” ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан ажлын туршлагатай.

**Гүйцэтгэх захирал:**

- Ө.Гантөр - Төрийн банкны Гүйцэтгэх захирал. СЭЗДС-ийг Банк санхүүч, бакалавр, KDI School of PPM Korea сургуулийг Удирдлагын ухааны магистрын зэргээр боловсрол эзэмшсэн. 1996-1997 онд “Монком” ХХК-д Нягтлан бодогч, 1997-1999 онд “ММ Инвест” банканд эдийн засагч, 1999-2011 онд Монголбанканд Хянан шалгагч, Ахлах хянан шалгагч, 2011-2013 онд Төрийн банканд Дэд захирал, 2013-2018 онд Монголбанканд Ахлах хянан шалгагч, 2018-2019 онд Төрийн банканд Байгууллагын банкны газрын захирал, 2019-2020 онд Төрийн банканд Тэргүүн дэд захирлаар тус тус ажилласан ажлын туршлагатай.

**Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод:**

Тус банкны ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд ТУЗ-ийн 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 56 дугаар тогтоолын дагуу өөрчлөлт оруулсан.

**Аудитын хороо**

| | | |
|---|---|---|
| Хорооны дарга: | С.Цэнд-Аюуш | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| Гишүүд: | З.Оюунцацрал | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| | Х.Пүрэвсүрэн | ТУЗ-ийн гишүүн |

**Эрсдэлийн удирдлагын хороо**

| | | |
|---|---|---|
| Хорооны дарга: | З.Оюунцацрал | ТУЗ-ийн хараат бус гишүүн Гишүүд: |
| | Б.Цэвэгжав | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| | Г.Золбоо | ТУЗ-ийн гишүүн |

**Нэр дэвшүүлэх хороо**

| | | |
|---|---|---|
| Хорооны дарга: | Б.Цэвэгжав | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| Гишүүд: | М.Батжаргал | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| | Х.Пүрэвсүрэн | ТУЗ-ийн гишүүн |

**Цалин урамшууллын хороо**

| | | |
|---|---|---|
| Хорооны дарга: | М.Батжаргал | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| Гишүүд: | С.Цэнд-Аюуш | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| | Х.Пүрэвсүрэн | ТУЗ-ийн гишүүн |

**Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглалын алба:**

"Төрийн банк" ХК-ийн дүрэмд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглалын албаны ажиллах журам" батлагдаж, тус албыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга ахлан ажиллаж, Банкны тухай хууль, Компанийн тухай хууль болон холбогдох бусад эрх зүйн баримт бичгийн хүрээнд ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглалын алба нь Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, "Төрийн банк" ХК-ийн дүрэм, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс", Монголбанкнаас баталсан "Банкны зохистой засаглалын журам"-ын хэрэгжилтийг хангуулах, банкны зохистой засаглалын бодлогыг хэрэгжүүлэх, Төлөөлөн удирдах зөвлөл болон Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны зохион байгуулалт, банкны үйл ажиллагааны тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг хангуулах, холбогдох тайлан, мэдээг цаг тухай бүр нь эрх бүхий байгууллагад хүргүүлэх, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд Засаглалын алба нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 1, ТУЗ-ийн хурал 7, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны хурал 13, Эрсдэлийн удирдлагын хорооны хурал 7, Нэр дэвшүүлэх хорооны хурал 5, Цалин урамшууллын хорооны хурал 1, нийт 34 хурлыг холбогдох журмын дагуу тус тус зохион байгуулж, хурлаар хэлэлцэх асуудлын хууль зүйн үндэслэл, холбогдох бусад эрх зүйн хэм хэмжээний нийцэл зэргийг хянан, холбогдох шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдээр хянуулан баталгаажуулж, тогтоолын биелэлтийг Гүйцэтгэх удирдлага болон Дотоод аудитын газраас гаргуулан хяналт тавьж ажиллалаа.

Мэдээлэл хянасан:
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Э.Уянга/

Мэдээлэл гаргасан:
Засаглалын албаны ахлах мэргэжилтэн /Г.Баясгалан/